

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
2022 ОНЫ 08 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧДААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 08 дугаар сарын 26

Улаанбаатар хот

ДҮД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	Үүрэг, даалгавар-НЭГ: 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлуудаа эрчимжүүлж, ажлын гүйцэтгэлийг газар дээр явж шалгах ажлыг шуурхай зохион байгуулах.			
1.	<p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/853 дугаар Захирамжийн хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2021 оны А/253 дугаар Захирамжаар 55 хүний бүрэлдэхүүнтэй 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг хэсгийг байгуулсан.</p> <p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2021 оны А/253 дугаар Захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2022 оны 08 дугаар сарын 24-ны өдөр цахимаар хуралдан өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэж, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажиглалаа.</p> <p>Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 12 салбарын 118 заалттай төлөвлөгөө боловсруулж, 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар, төлөвлөгөөний биелэлт 84,6%-тай байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ - 83,5% 2. Эрүүл мэндийн төв -80% 3. Боловсролын хэлтэс -90% 4. Онцгой байдлын хэлтэс -80% 5. ОСНААУГ Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6 -60% 6. ОСНААУГ Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7 -65% 7. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв -85% 8. “Чингэлтэй дүүргийн Тохижилт, үйлчилгээ” ХХК -100% 9. “Найши трейд” ХХК -80% 10. Гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээ хариуцсан “Соён дрийм” ХХК -83% 	=	<p align="center">Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	70

	<p>Хувийн халаалтын уурын зуухнууд:</p> <p>11. "Ану сервис" ХХК -95%</p> <p>12. "Элбэг дулаан" ХХК -90%-н тус тусын хэрэгжилттэй байна.</p> <p>Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ажлын тайланг сар бүрийн 30-ны өдөр холбогдох хэлтэс, албадаас авч ажиглаж байна.</p> <p>Дүүргийн 1-19, 24 дүгээр хороодын Засаг дарга нар 8 дугаар сарын 22-25-ны өдрийн хооронд өөрийн нутаг дэвсгэр дэх хамран сургах тойргийн ерөнхий боловсролын төрийн болон төрийн бус бага, дунд сургууль, цэцэрлэгийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь очиж танилцсан.</p> <p>Дүүргийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Таван толгой түлш" ХХК-ний сайжруулсан түлшний 100-н цэгээр борлуулалтыг хийж түгээнэ.</p> <p>"Таван толгой түлш" ХХК-с 2022-2023 онд сайжруулсан шахмал түлш борлуулах сонирхол бүхий иргэдэд зарыг хороо тус бүр ажлын алба болон, http://bitgel.ttt.mn/ цахим хаягаар хүргүүлэн 35 иргэн шахмал түлш борлуулах цэг ажиллуулах хүсэлт ирүүлснээс 21 иргэнийг сонгон шалгаруулна.</p> <p>Чингэлтэй дүүргийн хэмжээнд "Таван толгой түлш" ХХК-ний сайжруулсан шахмал түлшний 4 үндсэн агуулахад 10100 тонн түлшийг нөөцлөөд байна.</p> <p>Дүүргийн 2 дугаар хороонд Цахилгаан дамжуулах ХТГ-118 дэд өртөөний барилга, тоноглолыг бүрэн шинэчлэн барих, 6 кВ-ын цахилгаан дамжуулах нэг талын тэжээл нэмж татах ажил 2022.07.18-аас эхлэн 40%-н гүйцэтгэлтэй байна.</p>			
<p>2.</p>	<p>Үүрэг, даалгавар ХОЁР: Хөдөлгөөний ачаалал нэмэгдэхтэй холбогдуулан авто замын хөдөлгөөний дүрэм, журмыг мөрдүүлж, явган зорчигч болон хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлэх.</p> <p>Дүүргийн замын цагдаагийн хэлтэс нь замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилгоор Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй "Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт шалгалт хийх" арга хэмжээний хүрээнд хяналт шалгалтыг хийж зөрчил гаргасан жолооч нарт "Зөрчлийн тухай хууль"-н 14.7 дугаар зүйлийн 37 хэсэгт заасны дагуу 1690 жолоочийг 1.690.000 төгрөгөөр торгож ажилласан. Замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоцикл болон тээврийн хэрэгслийн яндангаас гарах дуу чимээ стандартын хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгслүүдэд хяналт шалгалтыг 2022 оны 08 дугаар сарын 22-25-ны хооронд зохицуулагч цагдаа нар хийж гүйцэтгэсэн. Стандартын шаардлага хангаагүй 21 тээврийн хэрэгслийн гэрчилгээг хурааж, Тээврийн цагдаагийн албанд хүргүүлсэн.</p>	<p>=</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	<p>50</p>

<p>Зам тээврийн ослоос урьдчилсан сэргийлэх зорилгоор дүүргийн гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зөвлөлтэй хамтран олон нийтийн цагдааг Тэнгис кино театр, Ард кинотеатр, Чингэлтэй дүүргийн хойд талын автобусны буудал болон 39 дүгээр сургуулийн өмнөх явган зорчигчийн гарцан дээр 4 олон нийтийн цагдааг хяналтаар ажиллуулсан.</p>			
<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Коронавируст халдвар (Ковид-19) болон Томуу, томму төст өвчний урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгүүдийг ариутгал халдваргүйтгэл, арга зүйн зөвлөмж, чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>			
<p>3. Хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд “Орхон овоот”, “Түвшин билэг төгөлдөр халдваргүйжүүлэлт” зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2022 оны 08 дугаар сарын 28-ны дотор ерөнхий боловсролын 28 сургууль, 54 цэцэрлэгийн ариутгал халдваргүйтгэлийг хийлгэхээр гэрээ байгуулсан.</p> <p>Өнөөдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 224 дүгээр цэцэрлэг 08 дугаар сарын 23-нд 1200 мкв ✓ 275 дугаар цэцэрлэг 08 дугаар сарын 23-нд 1200 мкв ✓ 293 дугаар цэцэрлэг 08 дугаар сарын 19-нд 1320 мкв ✓ 43 дугаар цэцэрлэг 08 дугаар сарын 23-ны өдөр 1942 мкв ✓ 222 дугаар цэцэрлэг 08 дугаар сарын 23-ны өдөр 600 мкв буюу нийт 6262 мкв талбайд халдваргүйжүүлэлт хийсэн. <p>Дүүргийн 16 дугаар хорооны 293 дугаар цэцэрлэгийн баруун талд чөлөөлсөн газарт нүхэн жорлонгийн суурь байсныг мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгэж, 3 метр өргөн 54 метр урт газарт явган зам хийж хүүхдийн эрүүл аюулгүй орчинд сурч хүмүүжих нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд Багш ажилчдыг эрүүл мэндийн нэмэлт үзлэг оношилгоонд хамруулах ажлыг 08 дугаар сарын 18-наас ЧДЭМТ дээр хийгдэж, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 1522 багш хамрагдсан.</p> <p>Чингэлтэй дүүргийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн шээс, цагаан хорхойн шинжилгээг ЭМТ-тэй төвтэй хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>		<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	70
<p>Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд шаардлагатай байгаа тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж, зөөлөн эдлэлээр хангах ажлуудаа шуурхай зохион байгуулах.</p>			
<p>4. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 218 дугаар тогтоолыг</p>	=	Үүрэг даалгаврын	70

<p>хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 10, 12, 18, дугаар хороодод нийт 300 хүүхдийн цэцэрлэгийн байрыг түрээслэх бэлтгэл ажлыг хангаж мөн хүчин чадлыг нэмэгдүүлэн хүүхэд хүлээн авч байгаа цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл сургалтын хэрэглэгдэхүүний судалгааг авч шат дараатай шийдвэрлэн ажиллаж байна. Шинээр ашиглалтад орсон 6 цэцэрлэгт 46 ширхэг хивс хивсэнцэр хүлээлгэж өгсөн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зөөлөн эдлэл” - 300 сая төгрөг тусгасан бөгөөд тендерийн шатандаа явагдаж байна.</p>	<p>Хэрэгжилт хангагдана</p>	
<p>Үүрэг, даалгавар ТАВ: Дүүргийн төсвөөс нийслэлд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө тасраад байгаа тул 8 дугаар сардаа орлогын төлөвлөгөөг бүрэн хангах, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 8 дугаар сарын төсвийн орлогын гүйцэтгэлийг хангалтгүй бүрдүүлсэн дүүрэг, газруудын удирдлагуудад хариуцлага тооцох.</p>		
<p>5. Чингэлтэй дүүргээс Нийслэлд төвлөрүүлэх нийт 101,019,0 сая төгрөгөөс эхний 7 сарын байдлаар 38,412,0 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 38,02%-н биелэлтэй ажиллаж байна.</p>	<p>=</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана 30</p>
<p>Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нийслэлийн Татварын газраас дүүргүүдийн Татварын хэлтсүүдийг удирдлага арга зүйгээр ханган, орлого бүрдүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, орлого бүрдүүлэх ажлаа эрчимжүүлж ажиллах.</p>		
<p>Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс нь 2022 оны 8 дугаар сарын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 8 сарын 24-ны байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Нийт төлөвлөгөө - 17,237.6 сая, гүйцэтгэл 9,894.6 сая, гүйцэтгэлийн хувь 57.4%-тай, өссөн дүнгээр орлогын гүйцэтгэлийн хувь 96.9% ➢ Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 2,350.2 сая, гүйцэтгэл 2,392.5 сая, гүйцэтгэлийн хувь 101.8%, өссөн дүнгээр гүйцэтгэлийн хувь 107.4% ➢ Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 144.5 сая, гүйцэтгэл 306.7 сая, гүйцэтгэлийн хувь 212.3%, өссөн дүнгээр гүйцэтгэлийн хувь 132.1% ➢ Дүүргийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 14,742.9 сая, гүйцэтгэл 7,192.1 сая, гүйцэтгэлийн хувь 48.7%, өссөн дүнгээр гүйцэтгэлийн хувь 89.4%-тайгаар ажиллалаа. 	<p>=</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана 70</p>
<p>6. Дүүргийн 1-6 дугаар хороодын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй ААН-г тоолсон үр дүнг гаргаж, өөр дүүрэгт бүртгэлтэй 121 ААН-үүдийг шалгаж, шилжүүлэн авах эсэхийг тодорхойлж, татварт хамруулах ажлыг Орлогын байцаагч нар гүйцэтгэж байна. Дүүргийн төсөвт төвлөрүүлэх татварын өр ногдолтой нийт 10357 татвар төлөгчийн 11.6 тэрбум төгрөгийн дутуу төлөлтийг хуваарийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>		

	Үүрэг, даалгавар	Долоо:	Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан төлөвлөгөөний төсөлд тусгах санал ирүүлсэн байгууллагууд өнөөдрийн дотор дахин нягталж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдтэй уулзаж саналаа нэгтгэн боловсруулж, эцэслэн танилцуулах.	
7.	Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан төлөвлөгөөний төсөлд нэмж тусгах саналаа ирүүлэхийг 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 7/2064 тоот албан бичгээр харьяа хэлтэс, албадад хүргэн ажиглав.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
	Үүрэг, даалгавар НАЙМ:	Нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгчид нийслэлийн 9 дүүрэгт өвөлжилтийн бэлтгэл ажил, хөрөнгө оруулалт болон авто замын түгжрэлийг бууруулах талаар хэрэгжүүлж байгаа ажлын явцтай танилцаж байгаатай холбогдуулан баталсан хуваарийн дагуу холбогдох байгууллагуудын удирдлагууд биечлэн оролцож, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах.		
8.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 103 дугаар захирамжийн дагуу тус дүүрэгээс НИТХ-д сонгогдсон Н.Батсүмбэрэл, Б.Мөнхбат, Л.Ариунтуяа, З.Төмөртөмөө нар 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр ирж тухайн дүүргийн өвөлжилтийн бэлтгэл ажил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт болон авто замын түгжрэлийг бууруулах талаар хийгдэж буй ажилтай танилцана.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
	Үүрэг, даалгавар ЕС :	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд хийгдэж байгаа тохижилтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, чанар, стандартад нийцсэн онцгой анхаарч ажиллах.		
9.	"Жишиг гудамж", Автобусны буудлын тохижилт, хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил, 293 дугаар цэцэрлэгийн баруун талд дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдэж байгаа явган замын тохижилтын ажилд 2022 оны 8 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Г.Батболд өөрийн биеэр очиж, ажигласан.			50
	Үүрэг, даалгавар АРАВ:	Нийслэлийн хүн амыг шинэ ургацын төмс, хүнсний ногоогоор хангах үзэсгэлэн худалдааны байршлуудаа нэмэгдүүлж ажлаа эрчимжүүлж ажиллах.		
10.	1.Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн А/138 дугаартай тушаалын хэрэгжилтийг хангаж дүүргийн 5 дугаар хороо Тусгаар тогтнолын талбай, 2 дугаар хороо "Эрдэнэ Булган" ХХК-ийн "Содон бөмбөгөр" худалдааны төвийн гадна талбайд "Алтан намар" үзэсгэлэн худалдааг тус тус зохион байгуулан ажиглаж байна. Тус үзэсгэлэн худалдаанд тусгаар тогтнолын талбай дээр			70

<p>40 иргэн, аж ахуйн нэгж, “Эрдэнэбулган” ХХК-ийн “Содон бөмбөгөр” худалдааны төвийн гадна талбайд 8 иргэн, аж ахуйн нэгж эх орны хөрсөнд тариалсан шинэ ургацын төмс хүнсний ногоо худалдаалж байна. Нийт 48 ААНБ, иргэн оролцож байна.</p> <p>2. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/138 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан байршлуудад дүүргийн 10, 17, 20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн талбайд “Намрын ногоон өдрүүд-2022” арга хэмжээнд 40 тонны багтаамж бүхий 4 чингэлэг суллаж, цэвэрлүүлэн байршуулж төмс, хүнсний ногоо худалдаалах дүүргийн иргэдээ ажлын байраар ханган ажиллахаар ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар АРВАН НЭГ: Гудамж, зам, талбайн хөдөлгөөний ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан дараах ажлуудыг эрчимжүүлж хяналт тавих. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Авто замын тэмдэг, тэмдэглэгээг будаж, өнгө үзэмжийг сэргээх, 2. Замын хайс, хашлагыг сэргээн засварлах, 3. Гэр хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтыг сайжруулах. 4. Гудамж, талбайн хог цэвэрлэгээ болон гэр хорооллын айл, өрхүүдийн хог тээвэрлэлтийг эрчимжүүлэх. 5. Золбин нохойг устгах ажлаа шуурхайлах. 			
<p>11.</p> <p>Дүүргийн Замын цагдаагийн хэлтсээс төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод, нээлттэй хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх чиглэлээр зам тээврийн осолд холбогдсон, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон иргэдийн бүрдүүлэх материал зэрэг мэдээ, мэдээлэл агуулсан хэлтсийн мэдээллийн самбарыг хийлгэж иргэд, жолооч нарыг мэдээллээр хангах зорилгоор “Утгах үйлчилгээний булан” ажиллуулсан. Хэлтсийн 39 алба хаагч нараас сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргуулахгүй ёс зүйтэй ажиллах баталгаа авч хэлтсийн дарга болон чиглэлийн ахлах офицер нар тогтмол хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Дүүргийн 10 дугаар хорооны Засаг дарга хорооны нийт өрхүүдэд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 06:00-23:00 цагийн хооронд нохой, муурыг эзэнгүй явуулахгүй байх бусдад болзошгүй аюул учруулахаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хорооны Хэсгийн ахлагч нараар хүргүүлэн ажиллалаа.</p>			50
<p>Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: Төрийн албан хаагч бүр ажил, албан тушаалаа хэрэгжүүлэхдээ иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулж, төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөж ажиллах.</p>			

<p>12. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын дарга нар ажлын эхний хэлтсийн хурал хийж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг хэлэлцэж, албан хаагчдад үүрэг чиглэл өгч ажилладаг. 2022оны 08 дугаар сарын байдлаар албан хаагчид, иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, ёс зүйн доголдолтой үйлдэл гаргаагүй. Удирдлагаас албан ёсны чөлөө авалгүйгээр ажлын байрыг орхиж явсан, албан бичиг шийдвэрлэх хугацаа хэтрүүлсэн зэрэг ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчдад сонсох ажиллагаа хийж, холбогдох арга хэмжээг авсан. Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад нийт 56 албан хаагчийг хамруулсан.</p>			90
--	--	--	----

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА М.НАВЧАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ж.ДУЛМАА

НЭЛТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ

